

# **СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ**

**2009 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ**

## **Соёлын өвийн төвийн 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний үйл ажиллагааны тайлан**

### **Тусгай захиалгат бүтээгдэхүүн**

#### **1. Дорнод, Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэсэн ажлын тухай**

Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо, суврага зэргийг бүртгэх тоолох” ажлын хүрээнд 2009 оны II улиралд Дорнод аймгийн, III улиралд Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ.

2009 оны 5-р сарын 18-наас 6-р сарын 24-ны хооронд Дорнод аймгийн 14 сумын нутаг дэвсгэрийг хамарсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх, тоолох ажлыг УНБМС-ийн мэргэжилтэн Б.Даваацэрэнгийн удирдсан сэргээн засварлагч-зураач Г.Соёл-Эрдэнэ, ажилтан П.Чинбат, Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын соёлын хяналтын улсын байцаагч Д.Мангалжав нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний баг хийж гүйцэтгэв. Судалгааны баг тус аймгийн нутаг дэвсгэрт нийт 7643 км зам туулж 161 дурсгалт газрын 3500 гаруй нэгж ширхэг дурсгалыг бүртгэжээ. Баг энэ ажлын хүрээнд 7200 орчим ширхэг гэрэл зураг, 30 орчим гар зураг, 140 орчим минутын дүрс бичлэг хийж баримтжуулсан байна.

2009 оны 9 дүгээр сарын 14-нөөс 10 дугаар сарын 23-ны хооронд Дорноговь, Говьсүмбэр аймгийн 17 сумын нутаг дэвсгэр дэх үл хөдлөх дурсгалыг бүртгэх, тоолох судалгааны ажлыг УНБМС-ийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, сэргээн засварлагч-судлаач Г.Соёл-Эрдэнэ, А.Мөнгөнцоож, П.Чинбат нарын бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэжээ. Тус баг Дорноговь Говьсүмбэр аймгийн нутагт 7731 км зам туулж 220 дурсгалт газрын 2300 орчим нэгж ширхэг дурсгалыг бүртгэжээ. Баг энэ ажлын хүрээнд 6800 гаруй гэрэл зураг 20 орчим гар зураг, 290 орчим минутын дүрс бичлэг хийж байримтжуулсан байна.

Хээрийн шинжилгээний баг нэр дурдсан дээр нэр дурдсан 3 аймгийн нутагт ажиллахдаа тухайн сум орон нутгийн удирдлага болон Соёлын төвийн ажилчид, сумын байгаль орчны байцаагч, багийн засаг дарга нартай хамтран ажиллаж Соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах, хяналт шалгалт хийх зэрэг чиглэлээр мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч, орон нутаг судлах кабинетэд чулуун зэвсгийн дээж, сүм хийдийн холбогдолтой эд зүйл зэрэг 70 орчим нэгж ширхэг эд өлгийн зүйл хүлээлгэн өгч сан хөмрөгийг нь арвижуулав.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг бүртгэн баримтжуулж, тоолоход Дорнод аймгийн 167, Дорноговь аймгийн 206, Говьсүмбэр аймгийн 16 булш хиргисүүр, хадны зураг, бичиг, эртний хотын туурь, сүм хийдийн туурь, хөшөө дурсгал, чулуун зэвсгийн үеийн болон палеонтологийн дурсгалт газрууд хамрагдсан байна.

Дээрх гурван аймгийн нутаг дэвсгэр дэх бүртгэл, тооллогод хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын “Монгол нутаг дахь үл хөдлөх дурсгал, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр аймаг” гэсэн цуврал 2 каталогийн хэвлэлийн эхийг бэлтгэн, хэвлэлтэнд шилжүүлээд байна.

## **Бүтээгдэхүүний анги-1**

### **1. Соёлын өвийг хамгаалах, улсын нэгдсэн бүртгэл-мэдээлийн сан бүрдүүлэх мэдээлэх үйлчилгээ**

#### **1.1 Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх журмыг шинэчлэн батлуулна.**

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн гол зорилт нь соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог сайжруулж, бүртгэн баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэхэд чиглэгдсэн. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх хууль эрх зүйг боловсронгуй болгон сайжруулах шаардлагатай байсан юм.

“Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” нь 1995, 2005 онуудад батлагдсан бөгөөд зөвхөн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэхэд зохицуулагдсан хязгаарлагдмал байсныг шинэчлэн боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 03-р сарын 09-ний өдрийн 78-р тушаалаар “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрүүлэх, уг санд бүртгэх журам”-ыг баталсан.

Шинэчлэн батлагдсан журам нь Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасанчилан а/соёлын өвийг хадгалж байгаа байгууллагын, б/сум, аймаг, нийслэлийн, в/улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан гэсэн шатлалын дагуу тус бүрийн бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааг нарийвчлан зааснаараа онцлог болсон юм. “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ыг улс, аймгийн музей, байгууллагад тараан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

#### **1.2 “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд улс, аймгийн музейгээс бүртгэн баримтжуулсан үзмэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгдэхүүнийг графикийн дагуу хүлээн авч, дижитал мэдээллийн сан бүрдүүлэх:**

*- 36 байгууллагатай байгуулсан “Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэл ирүүлэх гэрээ”-ний хавсралт №1-д заасны дагуу програм хангамжийг ашиглан бүртгэл хүлээн авах, УНБМСанд бүрдүүлэх талаар:*

“Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхэд улс, аймгийн музейн бүртгэл-мэдээллийн сангаас графикийн дагуу УНБМСанд үзмэрийн бүртгэлийг хүлээн авч бүртгэл, мэдээллийг бүрдүүлэн ажиллалаа.

2009 онд УНБМСанд графикт заасны дагуу улсын чанартай музей, эрдэм шинжилгээний байгууллага тус бүрээс 1200 ш бүртгэл, 21 аймгийн музей тус бүр 800 ш үзмэрийн бүртгэл буюу нийт 32300 үзмэрийг бүртгэх зорилт тавьснаас хөтөлбөрт хамрагдсан 36 байгууллагаас 2009 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар соёлын өвийн “РСН” бүртгэлийн програмын дагуу 15052 үзмэрийн бүртгэл ирүүлсэн байгаа нь бүртгэгдэх ёстой үзмэрийн 46.60 % нь бүртгэгдсэн байна. (Хавсралт № 1)

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийг хэрэгжилтийг хангахад, музейн сан хөмрөгийн 2007-2008 оны улсын тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээний тухай БСШУ-ны Сайдын 2008 оны 95-р тушаалын музейн үзмэрээ бүртгэн

баримтжуулж, байгууллагынхаа бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, үзмэрийн бүртгэлээ Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд ирүүлж байх заалтыг хэрэгжүүлэхэд Монголын Үндэсний музей, Чойжин ламын сүм музей, Дорнод аймгийн музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Гандантэгчилэн хийд зэрэг газрууд хангалтгүй ажиллаж байна.

УНБМСан нь музейгээс ирүүлж байгаа бүртгэлийн бүрдүүлэлтийг хянаж үзээд, заавар зөвлөмж өгөх, байгууллагынхаа бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх талаар болон УНБМСанд бүртгүүлэх ажлаа эрчимжүүлэхийг музей байгууллагуудад албан ёсоор мэдэгдэх зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Улс, аймгийн музейнүүд нь үзмэрийн бүртгэн баримтжуулалтанд шаардагдах хүний нөөц, бүртгэлийн програм, техник хэрэгслээр хангагдсан боловч байгууллагынхаа бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэл, мэдээллээ тогтмол ирүүлэх талаар улс, аймгийн музейн өөрсдийн идэвх санаачлагатай ажил дутагдаж байна.

2009 оны 7 дугаар сард “Үндэсний соёлын өвийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангахад улс, аймгийн музейн бүртгэн баримтжуулах ажил хийж байгаа ажилтнуудын болон хүлээлгэн өгсөн техник хэрэгслийн ашиглалтын талаарх судалгааг авч, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан дүнг нэгтгэн БСШУЯ-ны мэдээлэл, хяналт үнэлгээ, шинжилгээний газарт хүлээлгэн өгсөн.

- *Соёлын өвийн бүртгэлийн маягтын талаар:*

Түүх, соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийг 2006, 2007 онуудад батлагдсан маягтын дагуу бүртгэдэг бөгөөд харин албан ёсоор батлагдсан утга соёлын өвийг бүртгэх бүртгэлийн маягт байхгүй байсан. Иймд биет бус соёлын өвийн бүртгэлийн маягтыг шинээр боловсруулж, түүх, соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн маягтыг шинэчлэх, зарим нэг үг, найруулгыг өөрчлөх санал боловсруулсан.

“Монгол улсын биет бус соёлын өвийн бүртгэл”-ийг шинээр батлуулахаар, “Монгол улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг шинэчлэхээр, хөдлөх дурсгалт зүйл болох музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийн маягтын үг, найруулгыг “Монгол улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” гэж өөрчлөх саналыг БСШУЯаманд хүргүүлээд байна.

### **1.3 Бие бус соёлын өвийн мэдээллийн УНБМСанд бүртгэх, сан бүрдүүлэх талаар:**

Биет бус соёлын өвийн мэдээлэлийг УНБМСанд бүртгэх, сан бүрдүүлэх зорилгоор “Утга соёлын үндэсний төв” төрийн бус байгууллагад хадгалагдаж байсан ВЕТ 337ширхэг, VHS 17 ширхэг, UVW 68 ширхэг, DVcam 278 ширхэг утга соёл, аман өвийн тухай дуу дүрс бичлэгээр баримтжуулсан эх бичлэгтэй хальсийг УНБМСанд хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар ВЕТ хальснаас 188 ширхэгийг УНБМСанд болон Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтсийн дотоод ажилд зориулан тус бүр 2 хувийг DVcam, DVD хальсанд хуулан авсан байна. Энэ ажилд зориулан DVcam хальс 114 ширхэг, DVD-ROM 57 ширхэгийг тус төвийн дотоод үйл ажиллагааны зардлаас гарган зарцуулжээ. Тус төрийн бус байгууллагыг манай төвд нийлүүлэх үед үлй ажиллагааны зардлын төсөв огт тусгагдаагүй юм. Одоо “Утга соёлын Үндэсний төв” төрийн бус байгууллагад хадгалагдаж байсан үлдэгдэл хальсыг хуулбарлан авахад 475 ширхэг DVcam хальс, 238 ширхэг DVD-ROM хэрэгтэй гэсэн зардлын тооцоо гарчээ. Энэ зардлыг олох талаар анхаарах хэрэгтэй байна.

Соёлын биет бус өв, түүнийг тээгчийн бүртгэлийн маягт, “Соёлын биет бус өв түүнийг тээгчийг тогтоох үндэсний болон аймаг нийслэлийн салбар зөвлөлийн дүрэм”,

“Соёлын биет бус өв, түүнийг өвлөн тээгчийг тогтоох, бүртгэх журам” зэрэг өдөр тутмын үйл ажиллаанд мөрдөгдөх маягт, дүрэм, журмын төслийг боловсруулав.

2009 оны сүүлийн хагаст ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын дэмжлэгтэйгээр Хэнтий, Дорнод, Төв, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Архангай, Сэлэнгэ, Орхон аймагт соёлын биет бус өвийн түүвэр судалгаа хийж, аман билгийн төрлөөр 38, уламжлалт зан үйлийн чиглэлээр 6, ардын гар урлалын төрлөөр 10, нийт 54 өв тээгч авъяастныг сурвалжлан судлаж, ур чадвар, урын санг дуу, дүрс бичлэгээр баримтжууллаа.

#### **1.4. Утга соёлын өвийн үндэсний жагсаалт, болон ЮНЕСКО-д илгээх жагсаалтын талаар:**

Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн конвенцийн заалтын дагуу “Хүн төрөлхтний болон Үндэсний төлөөллийн бүртгэлд орох биет бус өвийн жагсаалт”, “Яаралтай хамгаалах шаардлагатай биет бус өвийн жагсаалт”-ыг төлөвлөн Соёл урлагийн бодлогын газарт оруулж, БСШУ-ны сайдаар батлууллаа. Цаашид эдгээр өвийг хамгаалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс, “Хүннү цуурын холбоо”-той хамтран Монгол цуур хөгжмийн уламжлалт урлагийг “Яаралтай хамгаалах шаардлагатай биет бус өв”-ийн дэлхийн жагсаалтад оруулахаар нэр дэвшүүлж, холбогдох тодорхойлолт, гэрэл зураг, аудио, видео, хэрэглэгдэхүүнийг бэлтгэн ЮНЕСКО-д илгээснээр 2009 оны 10 дугаар сард Монгол цуур хөгжим уг жагсаалтад албан ёсоор бүртгэгдлээ.

“Яаралтай хамгаалах шаардлагатай биет бус өв”-ийн дэлхийн жагсаалтад нэр дэвшүүлэх хэрэглэгдэхүүн болгож, “Монгол цуур”, “Монгол тууль” баримтат кино (англи, монгол хэлээр), “Уул усны цуурай” аудио CD бүтээв.

#### **1.5 Түүх, соёлын хосгүй үнэт 286 дурсгалт зүйлийн жагсаалтанд буй гэрчилгээ олгогдоогүй 55 дурсгалд “Хосгүй үнэт зэрэглэл”-д батлагдсан гэрчилгээ олгох:**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.4 дэх заалтын дагуу Засгийн газрын тогтоолоор 1995-2008 онуудад нийт 289 дурсгал түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалаар батлагдсан. Хуулийн 8.6-д заасны дагуу 1995-2005 онд түүх, соёлын хосгүй үнэт 234 дурсгалд 2006 онд “Хосгүй үнэт зэрэглэл”-д батлагдсан гэрчилгээг олгосон юм.

2009 онд тухайн үед гадаад орнуудад үзэсгэлэнд оролцож гэрэл зургийг авч чадаагүй шалтгаанаар гэрчилгээ нь олгогдоогүй байсан Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Монголын Үндэсний музей, Үндэсний номын сан, Эрдэнэ зуу зэрэг музейн 19 үзмэр, гэрэл зураг нь огт авагдаагүй Гандантэгчилэн, Төвхөн зэрэг 2 хийдийн 14 үзмэр, 2006-2008 онд зэрэглэлд шинээр батлагдсан Данзанравжаагийн музейн 7 ширхэг үзмэр, Өвөрхангай аймгийн Шанхын Баруун хүрээ хийдийн 15 үзмэр зэрэг нийт 55 дурсгалд гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Батлагдсан төсвийн дагуу гэрчилгээнд хавсаргах хосгүй үнэт дурсгалуудын гэрэл зургийг авч, БСШУЯамнаас баталсан загварын дагуу хэвлэлийн “Нью чанс” ХХК-иар гэрчилгээг хэвлүүлжээ.

2009 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран хосгүй үнэт дурсгалууд хадгалагдаж байгаа Монголын Үндэсний музей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей, Өвөрхангай аймгийн Шанхын Баруун хүрээ хийд, Дорноговь аймгийн музей зэрэг газруудад гэрчилгээ гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулсан.

Гандантэгчилэн хийдэд хадгалагдаж байгаа хосгүй үнэт дурсгалуудын гэрэл зургийг авч чадаагүйн улмаас гэрчилгээ олгогдоогүй үлдсэн байна.

### **1.6 Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх:**

*- Улс, аймгийн музейгээс сүм хийдэд шилжүүлсэн үзмэрийг газар дээр нь шинжээчийн баг ажиллуулж дүгнэлт гаргуулах ажлын талаар:*

БСШУ-ны сайдын 2008 оны 94 тоот тушаалын дагуу захирал Г.Энхбат, УНБМСангийн мэргэжилтэн, соёлын өвийн улсын байцаагч Б.Даваацэрэн, мэргэжилтэн Ш.Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй шинжээчийн баг 3 дугаар сарын 24-нөөс 5 дугаар сарын 04-ний хооронд Эрдэнэ-зуу музей, Архангай аймгийн музей, Дундговь аймгийн музей, Сэлэнгэ аймгийн музей, Булган аймгийн музей, Хөвсгөл аймгийн музей, Богд хааны ордон музей зэрэг 7 музейн сан хөмрөгөөс сүм хийдэд гэрээгээр эзэмшүүлж байгаа үзмэрийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор газар дээр нь очиж биечлэн үзэж үнэлгээ, дүгнэлт гаргалаа.

Ажлын хэсэг 7 музейгээс 10 сүм хийдэд ашиглагдаж байсан нийт 3598 үзмэрээс 404 үзмэр үрэгдсэн болохыг тогтоож, 1195 үзмэрийг музейн сан хөмрөгтөө авах (үүний 373 үзмэрийг гэрээгээр үлдээсэн), сүм хийдэд 1105 үзмэрийг шилжүүлэх, сүм хийдийн ашигласан 894 үзмэрийг мөн нэмэгдсэнээр нийт 1999 үзмэрийг сүм хийдэд бүрэн шилжүүлэх шийдвэр гаргалаа.

*- Улс, аймгийн музейгээс шилжүүлэх үзмэрээр Улаанбаатар хотод нэгдсэн үзэсгэлэн зохион байгуулсан талаар:*

2007-2008 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогоор нэг төрлийн хэт олон тоотой, тухайн музейн үзмэр цуглуулгын бодлогод нийцэхгүй, гэмтэлтэй муудсан үзмэрийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг Монголын үндэсний музейн захирлын 2009 оны 04-р сарын 13-ны өдрийн 27-р тушаалаар батлан, үзмэр шилжүүлэх үзэсгэлэнг 2009 оны 4-р сарын 30-наас 5-р сарын 4-ний өдрүүдэд Монголын үндэсний музей дээр зохион байгууллаа.

Үзэсгэлэнд нэр бүхий 19 музейн 3889 нэрийн 14799 ширхэг үзмэр оролцохоос 16 музей 9575 үзмэрээ авчиран оролцсон. Үүнээс 5420 үзмэрийг шилжүүлж, 4156 үзмэр үлдсэн байна.

Үзэсгэлэнд үзмэрээ авчирч оролцсон 16 музей өөр хоорондоо 1045 үзмэр, үзмэр авах зорилгоор оролцсон Говь-сүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Өмнө-говь, Сэлэнгэ, Увс аймгийн музей, Төрийн түүхийн музей, Улс төрийн хэлмэгсдийн дурсгалын музей, Соёлын өвийн төв, Уламжлалт анагаах ухааны музей, Улсын драмын эрдмийн театр, Монгол кино нэгтгэл, Урчуудын эвлэлийн хороо болон 11 сүм хийд нийлсэн 25 байгууллага 4375 үзмэр, нийт 5420 үзмэрийг шилжүүлэн авсан байна.

*- “Монголын музейн үзмэрүүд” гэсэн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн цуврал каталог хэвлүүлэх ажлыг зохион байгуулах талаар:*

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 345 дугаар тушаалын дагуу зохион байгуулагдсан улс, аймгийн музейн сан хөмрөгийн 2007-2008 оны улсын тооллогоор тоологдсон үзмэр, эд өлгийн зүйлийг Монгол Улсын өмчлөлд байгааг баталгаажуулан түүнийг хулгайд алдагдах, хууль

бусаар солих, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлж, ажлын хэрэгцээнд ашиглах, сурталчлахад зорилгоор улс, аймгийн музейн үзмэрийн гэрэл зургийн цомог хэвлүүлэх, цахим каталоги хийх төслийг боловсруулан БСШУЯаманд хүргүүлсэн.

Энэхүү “Монголын музейн үзмэрүүд” цомогт музейд хадгалагдаж байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалуудыг хамруулах бөгөөд цугларсан материал хэрэглэгдэхүүн дээр үндэслэн цахим каталоги хийж олон нийтэд сурталчлах юм.

Монгол Улсын Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу БСШУЯамтай хамтран “Монголын музейн үзмэрүүд” цомгийн гэрэл зураг авах, хэвлэлийн эх бэлтгэх, цахим каталоги хийх ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах 3-н багц тендерийг 2009 оны 11 дүгээр сард зарлан зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулаад байна.

Сонгон шалгаруулалтын дүнгээс үзэхэд “Монголын музейн үзмэрүүд” цомгийн гэрэл зураг авах 1 дүгээр багцын сонгон шалгаруулалтанд “Ирмүүн мальтимедиа ХХК” тендерийн болзолыг хангаж шалгарсан бөгөөд хэвлэлийн эх бэлтгэх, цахим каталоги хийх 2 ба 3 дугаар багцад шалгарах гүйцэтгэгч шалгараагүй тул тендерийг дахин зарлахаар шийдвэрлэсэн болно.

“Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомог хэвлүүлэх бэлтгэл ажил болон цахим каталоги хийх ажил нь 2010 оны эхний хагас жилд хийгдэх юм.

## Бүтээгдэхүүний анги -2

### 2. Түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлчилгээ

#### 2.1 Улс, аймгийн 13 музейн 161 ширхэг үзмэрийг бэхжүүлэх сэргээн засварлах:

2009 онд Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс нь улс, аймгийн 13 музейн 161 үзмэрийг бэхжүүлж сэргээн засварлахаар төлөвлөснөөс оны эцсийн байдлаар 13 музейгээс нийт 167 ширхэг үзмэр сэргээн засварлахаар хүлээж авсан.

№	Байгууллага	Нийт сэргээн засварлах үзмэрийн тоо	Хүлээж авсан үзмэрийн тоо	Сэргээн засварлагдсан үзмэрийн тоо	Сэргээн засварлагдсан аж байгаа үзмэрийн тоо	Засварт ороогүй үзмэр
1.	Булган аймгийн музей	34	34	34		
2.	Богд хааны ордон музей	6	6	6		
3.	Дархан-уул аймгийн музей	15	15	15		
4.	Дорно-говь аймгийн музей	11	11	11		
5.	Дүрслэх урлагийн музей	11	11	11		
6.	Хөвсгөл аймгийн музей	6	6	5	1	
7.	Хэнтий аймгийн музей	10	10	9	1	
8	Өвөрхангай аймгийн музей	5	5	5		
9.	Монголын	30	30	30		

	үндэсний музей					
10	Театрын музей	7	7	7		
11	Халх-голын музей	5				5
12	Орхон аймгийн музей	2	2	2		
13	Уран зургийн галерей	30	30	28	2	
	<b>Нийт</b>	<b>172</b>	<b>167</b>	<b>163</b>	<b>4</b>	<b>5</b>

*Сэргээн засварлах ажил хийгдэж байгаа үзмэрүүдээс:*

Хөвсгөл аймгийн музейн 145 см өндөр, зэс хөөмөл алтан шармал Мэгжид жанрайсиг бурхан бүх залгаасаараа салж гэмтснийг сэргээн засварлаж, гар, суурь бад, гарын бүх барьц дутуу зүйлсийг гүйцээх ажил хийгдэж байна.

Хэнтий аймгийн музейн Таравчимба судрыг хорхой их хэмжээгээр идсэн, чийгний гэмтлээс шалтгаалж хуудас нь хоорондоо наалдсан тул хуудас бүрийг нэг бүрчлэн салгаж цэвэрлэх ажиллагаа хийгдэж байна

Уран зургийн галерейгаас их чийгтэй орчинд удаан хугацаанд байснаас шалтгаалж гэмтсэн 12 ширхэг зээгт наамал бүтээлээс “Баянхонгорын дагина” 200x130 см, “Өнөөгийн жавхаа” 260x185 см зээгт наамал бүтээлүүдийн гэмтэл маш их, хэмжээний хувьд том зэргээс шалтгаалж сэргээн засварлалт нь бүрэн дуусаагүй байна.

Дорнод аймгийн Халх голын ялалтын музейгээс 5 ширхэг үзмэр сэргээн засварлах төлөвлөгөөнд орсон ч тус музейгээс үзмэр нь ирээгүй.

*Нэмэлт захиалгаар засварласан үзмэрүүд:*

Богд хааны ордон музейн 4 ширхэг модон сийлбэр, Монголын үндэсний музейн 1 ширхэг үзмэр, хүн чулуун хөшөө, Чойжин ламын сүм музейн 1 ширхэг чулуун баганын сэргээн засварлатын ажлыг гүйцэтгэсэн.

Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, ОХУ-ын Буриадын Монгол-Түвд-Буддын судлалын хүрээлэнгийн хамтарсан судалгааны анги 2009 оны 7 дугаар сард Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Шороон бумбагар хэмээх газраас Түрэгийн эзэнт гүрний үед холбогдох бунхныг судлах малтлагын үеэр тус бунхнаас олон тооны өвөрмөц сонин олдворууд гарсныг 2009 оны 7 дугаар сарын 13-16-ны хооронд малтлагын талбай дээр тус төвөөс сэргээн засварлагч ажиллаж, олдворуудад анхан шатны хамгаалалт бэхжүүлэлтийг хийж авчирсан.

Зарим шаардлагатай 50 гаруй олдворуудыг 2009 оны 9 дүгээр сараас 12 дугаар сарын хооронд цэвэрлэж бэхжүүлэх, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.

## **2.2 Монголын уран зургийн галерейн 200 ширхэг уран зургийг утаа тортогний бохирдлоос цэвэрлэх:**

2008 оны 7 дугаар сарын 1-ны үйл явдал, 2009 оны 5 дугаар сарын 18-нд тус музейн сан хөмрөгт гарсан галнаас утаа тортогт бохирдож, усанд норж гэмтсэн 900 гаруй зургаас энэ жил 200 ширхэг зураг цэвэрлэхээр төлөвлөсний дагуу 186 ширхэг зургийг цэвэрлэж дууссан ба 4 ширхэг зургийн цэвэрлэгээ хийгдэж байна.



2009 оны 11 дүгээр сарын 22- ноос 23-нд шилжих шөнө тус төвийн зураг сэргээн засварлах өрөөнд гал гарсны улмаас тодорхой хугацаагаар зураг сэргээн засварлах цэвэрлэх үйл ажиллагаа саатаж, дээрх зургийн цэвэрлэгээний ажил бүрэн дуусаагүй байна.

### **2.3 “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7.4-т заасан:**

- *Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгойн хүн чулуу, Булган аймгийн Сайхан сумын Моюунчурын гэрэлт хөшөөг Улаанбаатар хотод нүүлгэн шилжүүлэх:*

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 303 дугаар тогтоолоор баталсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг дэвсгэрт орших Таван толгой дахь Монголын эзэнт гүрний үед холбогдох, гантиг чулуугаар маш уран дүрслэж бүтээсэн 2 ширхэг хүн чулууны өнөөгийн байгаа байдалтай танилцах, бэхжүүлэх, хэв авч хуулбарыг хийж музейд байрлуулах зорилгоор 2009 оны 6 дугаар сарын 8-16-ны хооронд Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, ахлах сэргээн засварлагч С.Чинзориг, сэргээн засварлагч Д.Нямдорж, Н.Жамбал, А.Мөнгөнцоож, Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн Г.Гонгоржав нарын бүрэлдэхүүнтэй баг газар дээр нь ажилласан.

Булган аймгийн Сайхан сумын Моюунчурын гэрэлт хөшөөг Улаанбаатар хотод нүүлгэн шилжүүлж, Үндэсний түүхийн музейд байрлуулах ажлыг 2009 оны 9 дүгээр сарын 5-наас 10-ны хооронд хийж гүйцэтгэхээр орон нутагт ажилласан хэдий ч нутгийн засаг захиргаа үл зөвшөөрсөн шалтгааны улмаас нүүлгэн шилжүүлэх ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.

### **2.4 “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7.5, 7.3-4-т зааснаар 2009 онд**

- *Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны дурсгал, Хэнтий аймгийн Баянхутаг сумын Сэрвэн хаалганы дурсгалыг хамгаалах бэхжүүлэх сэргээн засварлах*

Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны дурсгал, Хэнтий аймгийн Баянхутаг сумын Сэрвэн хаалганы дурсгалыг хамгаалах бэхжүүлэх сэргээн засварлах ажлын хүрээнд уг дурсгалуудын өнөөгийн гэмтэл бохирдол, байгаль цаг агаарын нөлөөлөл зэргийг судлахаар Япон улсын Токио хотын соёлын өвийг хамгаалах судалгааны хүрээлэн, Нара хотын соёлын өвийг хамгаалах судалгааны хүрээлэнтэй хамтран 2009 оны 8 дугаар сарын 19 –ноос 14 хоногийн хугацаанд орон нутагт ажиллаж, судалгааны ажлын дээжүүдийг Нара хотын соёлын өвийг хамгаалах судалгааны хүрээлэнд шинжлүүлэхээр явуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 303 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутаг дэвсгэрт орших Монголын эзэнт гүрний үед холбогдох, байгалийн боржин чулуун дээр сийлбэрлэж бүтээсэн 2 хэсэг бичээсний өнөөгийн нөхцөл байдалтай танилцаж, уг бичээсүүдийг сийлбэрлэсэн боржин чулууны гадаргуу нь байгаль цаг агаарын нөлөөллөөр сайрч хэврэгшин, хуурч ховхролт үүсэж, их хэмжээгээр гэмтэн муудаж байгаа тул бичээсний хэвийг авч хадгалах, бэхжүүлэх, хуулбарыг хийж музейд

байрлуулах ажлыг хийж гүйцэтгэхээр 2009 оны 9 дүгээр сарын 15-20 -ны хооронд Соёлын өвийн төвийн ахлах сэргээн засварлагч С.Чинзориг, сэргээн засварлагч Д.Нямдорж, Н.Жамбал, С.Даваадарь нарын 4-н хүний бүрэлдэхүүнтэйгээр газар дээр нь очиж ажилласан.

## **2.5 2009 он “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”**

- *Дурсгалт газруудад танилцуулгын чулуун самбар байрлуулсан талаар:*

2007 оны Монгол улсын засгийн газрын 303 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-т тусгагдсаны дагуу 2008-2009 онд хийж гүйцэтгэх ажлын хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших “Рашаан хад”, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутөгт орших “Хэрлэн барс” хот, Дорнод аймгийн Халх гол сумын нутагт орших “Их бурхант” дурсгалын дэргэд нэг загварын чулуун танилцуулга самбарыг байрлуулах ажлаар тус төвийн Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, мэргэжилтэн Б.Алтансүх, Д.Нямдорж, Н.Жамбал нар болон чулуун бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулдаг “Бодь буян” ХХК-ний 3 мэргэжилтний хамт 2009 оны 5 дугаар сарын 15-наас 25-ыг хүртэл 10 хоногийн хугацаатай ажиллав.

Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Алтан сандал уулын буган чулуу, мөн аймгийн Тариат сумын нутагт орших Чулуут голын хадны зураг, Булган аймгийн Баян-Агт сумын Шивээт-Улааны дурсгалын дэргэд чулуун танилцуулга самбар байрлуулах ажлыг 2009 оны 7 дүгээр сарын 15-наас 25-ний хооронд хийж гүйцэтгэсэн.

- *Соёлын өвийг судлах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх талаар:*
- Соёлын өвийг судлах хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Соёлын өвийн төв болон АНУ-ын Вильямстоуны сэргээн засварлах төв монголын урлагийн зөвлөлийн хооронд байгуулсан санамж бичиг болон мэргэжилтэн солилцох хөтөлбөрийн хүрээнд Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч Д. Нямдорж, Г. Соёл-эрдэнэ нар мэргэжлийн дадлага, туршлага судлах зорилгоор 2009 оны 3-р сарын 3-наас 27-ний хооронд 25 хоног Вильямстоуны сэргээн засварлах төвд тус төвийн үйл ажиллагаатай танилцаж сэргээн засварлагчидтай хамтран ажилласан.
- 2009 оны 6 дугаар сарын 23-наас 7 дугаар сарын 01-ний хооронд АНУ-ын Виллямстоун хотын уран зураг сэргээн засварлах төвийн 2 мэргэжилтэн тус төвд 7 хоногийн хугацаанд уран зураг, даавуу зөөлөн эдлэл сэргээн засварлах арга зүй, зарим тоног төхөөрөмжийн талаар танилцуулан, хоёр орны арга зүйгээр харилцан ярилцан санал солилцов. Мөн 2009 оны 5 дугаар сарын 19-нд Уран зургийн сан хөмрөгийн өрөөнд болсон гал түймрийн улмаас шатсан, гэмтсэн зурагтай газар дээр нь танилцаж, цаашид түүнийг сэргээн засварлахад шаардлагатай арга зүй болон зарим тоног төхөөрөмжийг хэрхэн олох зэрэг талаар ярилцав.

- Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Токиогийн соёлын өвийг хамгаалах үндэсний судалгааны хүрээлэнтэй хамтран Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт орших Балдан бэрээвэн хийдэд “Сүм хийдийн өнгө будгийн чимэглэлийг тодорхойлж, баримтжуулах” сургалт дадлагыг 2009 оны 7 дугаар сарын 23-наас 28-нд хооронд зохион байгуулсан.

Тус сургалтанд Токиогийн соёлын өвийг хамгаалах судалгааны хүрээлэнгийн гадаад харилцааны дарга Симузу, гадаад харилцааны мэргэжилтэн Юүми Изабелла Акида, тус хүрээлэнгийн сэргээн засварлалт хадгалалт стандарт техникийн хэлтсийн дарга Нобукино Китано, тус хүрээлэнгийн сүм хийдийн өнгө будгийн сэргээн засварлалтын ажлын зураг төслийн мэргэжилтэн Мотто, сүм хийдийн өнгө будгийг хамгаалалт, сэргээн засварлалтын компанийн гүйцэтгэгч Хаяато Ономура нар хичээл зааж удирдсан ба тус төвийн сэргээн засварлагч С.Чинзориг, Г.Соёл-Эрдэнэ, Д.Нямдорж, А.Мөнгөнцоож нар оролцсон.

- 2009 оны 9 дүгээр сарын 4-нөөс 10 дугаар сарын 4-ний хооронд Япон улсын Нара хот дахь ЮНЕСКО-гийн Ази, Номхон далайн орнуудын соёлын өвийг хамгаалах хамтын ажиллагааны хүрээлэнгээс “Модоор бүтээгдсэн соёлын өв”-ийг хамгаалах, сэргээн засварлах дадлагажих сургалтанд тус төвийн сэргээн засварлагч О.Оюунчимэг оролцож, мэргэжил дээшлүүлсэн.
- 2009 оны 11 дүгээр сарын 16-наас 12 дугаар сарын 17-ний хооронд Япон улсын Нара хот дахь ЮНЕСКО-гийн Ази, Номхон далайн орнуудын соёлын өвийг хамгаалах хамтын ажиллагааны хүрээлэнгийн салбараас археологийн олдвор, сүм хийдийн барилгын гадна, дотор талын өнгө будгийн чимэглэлийг сэргээн засварлах чиглэлээр зохион байгуулсан дадлагажих сургалтанд тус төвийн сэргээн засварлагч С.Чинзориг, Д.Нямдорж, С.Даваадарь нар оролцож мэргэжил дээшлүүлсэн.

## **Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй бусад ажил:**

*-Соёлын өвийн төвийн бүтцийн өөрчлөлт, бусад ажлын талаар:*

- Соёлын өвийн төв нь Монголын Улсын Засгийн газрын “Соёлын өвийн төвийг өргөжүүлэх тухай” 2008 оны 302-р тогтоол, БСШУ-ны сайдын “Соёлын өвийн төвийг өргөжүүлэх тухай” 2008 оны 47-р тушаалын дагуу 2009 оноос эхлэн шинэ бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 125-р тушаалаар Соёлын өвийн төвийн шинэчлэн батлагдсан дүрэмд зааснаар байгууллагын бүтцийг “Биет соёлын өвийг хамгаалах хэлтэс”, “Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтэс”, “Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс” гэсэн 3 хэлтэс, Захиргааны албатай болгон өөрчлөн зохион байгуулж, хэлтсийн дарга нарыг томилон, үүрэгт ажилд нь оруулав. Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн даргаар Д.Нарантуяаг, Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтсийн даргаар С.Юндэнбатыг, Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах хэлтсийн даргаар С.Чинзоригийг тус тус томилсон.

Байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн өргөжин, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Хөдөлмөрийн дотоод журам”, ажилтнуудын

ажлын байрны тодорхойлолт, 3-н хэлтэс тус бүрийн ажлын дотоод журмыг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж эхлээд байна.

- “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7.1-т “Соёлын өвийн төвийг зориулалтын барилгатай болгохоор заасны дагуу тус төвийн шинэ барилгын газрыг асуудлыг шийдвэрлэн, 2010 онд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2009 оны 4-р сарын 22-ны өдрийн “Улсын үзлэг явуулах тухай” 37-р захирамжийн 2-р хавсралт “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамж”-д заасны дагуу архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлыг Соёлын өвийн төвийн захирлын тушаалаар батлагдсан “Баримт бичгийг нягтлан шалгах комисс” зохион байгуулан ажилласан.

Ажлын хүрээнд Соёлын өвийн төвийн “байнга хадгалах”, “70 жил хадгалах”, “түр хадгалах”, “устгах” хадгаламжийн нэгжийн бүртгэлүүдийг тус бүр цэгцлэн, байгууллагын архив, бичиг хэрэг хөтлөлт, архивын өрөөний орчинг сайжруулах арга хэмжээ авч ажиллан тайланг БСШУЯаманд хүргүүлсэн. Архивын хуулийн дагуу “Соёлын өвийн төвийн байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл”-ийг Улсын төв архивт шилжүүлэхэд бэлэн болгоод байна.

*- Соёлын өвийн хадгалалт хамгаалалт, ажилтнуудыг сургалт, семинарт хамруулсан талаар:*

- 2009 оны 4, 5-р саруудад нийслэлийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран нийслэл хотын нутаг дэвсгэрт байрлах Богд хааны ордон музей, Байгалийн түүхийн музей, Дүрслэх урлагийн музей, Монголын театрын музей, Монгол цэргийн музей зэрэг 5 музейн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ судалгааны байдлын талаархи хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтанд УНБМСангийн мэргэжилтэн, соёлын өвийн байцаагч Б.Даваацэрэн оролцон ажилласан.
- 2009 оны 4-р сарын 27-ноос 28-ны өдрүүдэд Булган аймагт болсон сумын соёлын төвийн эрхлэгч нарт зориулсан сургалтанд УНБМСангийн мэргэжилтэн Б.Даваацэрэн “Соёлын өвийг бүртгэх, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх”, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж хамгаалах” сэдвээр 4 цагийн хичээл, 2009 оны 4-р сарын 30-нд “Үзмэр шилжүүлэх үзэсгэлэн”-гийн үеэр музейн ажилтнуудад зориулан зохион байгуулсан “Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, судалгаа ба тайлбарын тулгамдсан асуудал” сэдэвт сургалт семинарт Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа “Соёлын өвийн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, соёлын өвийн бүртгэл”-ийн тухай 1 цагийн хичээлийг тус тус заасан.
- 2009 оны 4-р сарын 6-наас 8-нд Архивын ерөнхий газрын сургалтын төвөөс зохион байгуулсан “Архив бичиг хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх нь” мэргэшүүлэх сургалтанд Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа, УНБМСангийн програмист Б.Алтансүх нар хамрагдсан.

- 2009 оны 5 дугаар сард Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтнүүд “Монгол хөөмий” олон улсын симпозиум, фестивалийг зохион байгуулах комисст оролцож, наадмын үйл ажиллагааг баримтжуулах, илтгэл тавих, уралдаанд шүүгчдийн бүрэлдэхүүнд орж ажиллах зэргээр хамтран оролцов.
- 2009 оны 6 дугаар сард Аймгийн ЗДТГын дэргэдэх БСГазар, Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтнүүд хамрагдсан сургалт семинарт захирал Г.Энхбат “Соёлын өвийг бүртгэн баримтжуулахад орон нутгийн мэргэжилтнүүдийн үүрэг” сэдвээр, Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга С.Юндэнбат “Соёлын биет бус өвийг хамгаалах арга зам, түүнийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх нь” сэдвээр тус тус хичээл заав.
- Монголын шашин, соёлын нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, Ламын гэгээн Лувсанданзанжанцаны түмэн өлзий гийсний 370 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал, “Ламын гэгээн Лувсанданзанжанцаны эрдэм ухааны өв” сэдэвт үзэсгэлэнг (2009.IV.15) Улаанбаатар хот дахь Баянхонгор аймгийн нутгийн зөвлөл, Үндэсний музейтэй хамтран зохион байгуулж, эрдэм шинжилгээний илтгэлүүдийн эмхтгэл, ламын гэгээнтэний намтар, цадиг, буман зарлигийн цуврал ном хэвлүүлэв.
- 2009 оны 6 дугаар сарын 24-нөөс 7 дугаар сарын 01-нд Японы Киото хотын Дошиша Их сургуулийн дижитал технологийн багш Цумура тэргүүтэй 4 хүний бүрэлдэхүүнтэй баг монголын түүх, соёлын дурсгалыг 3 хөдөлгөөнт хэмжээс бүхий дижитал гэрэл зургаар баримтжуулах зорилгоор тус төвийн Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн болон програм хангамжийн мэргэжилтний хамт ажиллав. Судалгааны баг монголын түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг баримтжуулахад ямар тоног төхөөрөмж хэрэглэж болох талаар судалгаа хийж 3 төрлийн дурсгалд хөдөлгөөнт баримтжуулалтын туршилт хийв. Үүнд, Чойжин ламын сүм музейн ердийн дурсгал болох шавар Занабазар бурхан, Гачууртын хадны зураг, Тоньюкукийн дурсгалт газар хамрагдав.
- 2009 оны 6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 01-ний хооронд ЮНЕСКО-ийн Монголын үндэсний хороо, Солонгос улсын Соёлын агуулга бүтээх Агентлагаас хамтран зохион байгуулсан “Монгол улс дахь уламжлалт болон орчин үеийн соёлын бүтээлээс шинэ агуулга үүсгэх, түүнийг мэдээллийн нэгдсэн тоон системд оруулах үндэсний чадавхийг сайжруулах нь” сэдэвт сургалтанд тус төвийн мэргэжилтэн П.Чинбат оролцов.
- Япон улс дахь ЮНЕСКО-гийн Ази-Номхон далайн Соёлын төв (ACCU) зохион байгуулсан Биет бус өвийг хамгаалах 3 дугаар сургалт семинарт (2009.07.15-22, Киото, Нара, Осака) тус хэлтсийн ажилтан Ж.Насанжаргал, У.Сайнбаяр нар оролцов. Уг сургалт семинарт Ази номхон далайн 22 орны төлөөлөгчид оролцож, СББӨ-ийг хэрхэн хамгаалж, бүртгэн баримтжуулж буй арга туршлагаа хуваалцаж, уг ажлын ижил төстэй ба ялгаатай тал, тохиолдож буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам, шалгуурын асуудлаар санал бодлоо солилцсоны дээр Япон улс ББСӨ-ийг хамгаалах талаар хуримтлуулсан туршлагаа танилцуулж, сургалт дадлага зохион байгуулсан болно.

- “Монголын биет бус соёлын өвийг хамгаалж дэмжих асуудалд” сэдэвт симпозиум, “Хүн-амьд эрдэнэ системийг хэрэгжүүлэх арга зам” сэдэвт семинарыг (2009.9.07-10, Улаанбаатар) БСШУЯ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, Солонгосын “Ази номхон далайн биет бус соёлын өвийн төв”-тэй хамтран зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд төв, хөдөөгөөс 60 гаруй төлөөлөгч, ардын авъяастан, уран дархан, уламжлалт технологийг эзэмшсэн ур чадвартнууд, судлаачид, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудын төлөөлөл оролцов.
  - Соёл урлагийн хороо, Өвөрхангай аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан “Сайн ноён хан аймгийн уртын дууны наадам”-ын (2009.Х.07-09, Арвайхээр) үйл ажиллагааг дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай аймгаас шалгаран оролцсон уртын дуучид, хуурчид, ардын авъяастнуудын дунд “Уртын дууны уламжлалт өвийг хамгаалах арга зам” сэдвээр ярилцлага зохион байгуулав.
  - ЮНЕСКО, Монголын үндэсний комиссоос санаачлан зохион байгуулсан “Биологийн болон соёлын төрөл зүйлийг хамгаалахад тахилгат газар нутгийн ач холбогдол” сэдэвт эрдэм шинжилгээний хурал (2009.10.26. Улаанбаатар), “Монгол дахь Дэлхийн өвийн боловсрол, ба тогтвортой хөгжил” сургалт семинарт (2009.10.18-21. Хархорин) тус хэлтсийн ажилтнууд оролцож, биет бус соёлын өвийн чиглэлээр илтгэл тавьж, хичээл заалаа.
- *Судалгаа, сурталчилгааны ажлын талаар:*
- Соёлын өвийн төв нь [www.monheritage.mn](http://www.monheritage.mn) <<http://www.monheritage.mn>> веб сайтаар дамжуулан соёлын өвийг хадгалж хамгаалах, бүртгэх, сурталчлах талаар хийгдэж буй үйл ажиллагааг түгээх, сурталчлах ажлыг тасралтгүй байнга явуулж байгаа бөгөөд веб сайтаа өргөтгөн шинэчлэх ажлыг хийж байна.
  - 2009 онд “Соёлын өв” мэдээлэл сурталчилгааны сэтгүүлийн 2 дугаараар, тус бүр 100 хувиар хэвлүүлэн, улс, аймгийн музей, эрдэм шинжилгээний байгууллага, соёлын өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, номын сан, их, дээд сургуулиудын номын сан, бүх аймгийн сумын соёлын төвүүдэд тараасан. Оны сүүлчийн дугаараас эхлэн тус сэтгүүлийг улсын хэвлэлийн бүртгэлд албан ёсоор бүртгүүлэн, “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” нэртэйгээр хэвлүүлсэн.  
Тус сэтгүүлийн дугааруудад соёлын өвийг бүртгэх, сэргээн засварлах, хамгаалах талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ судалгаа, мэргэжил арга зүй, мэдээллийг хэвлэн нийтлүүлсэн.
  - ЮНЕСКО-гоос зохион байгуулж байгаа Соёлын өвийн төв, Үндэсний номын сан, Үндэсний архивын газар, Гандантэгчинлэн хийд, ШУА-ийн хэл шинжлэлийн хүрээлэн зэрэг 5 байгууллагын хамтарсан “Цаасан баримтыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах” төслийн цаасан баримтат соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр сэргээн засварлагч О.Оюунчимэг, Д.Нарантуяа нар оролцон ажиллаж байна.

ЮНЕСКО-гоос зохион байгуулж байгаа энэхүү төсөл нь БНСУ, БНХАУ, Япон, Монгол зэрэг Азийн орнуудыг хамарч байгаа бөгөөд 2008 оноос эхлэн 5 жилийн хугацаатай хэрэгжих юм. Төслийн эхний шатны ажил болох монгол оронд цаас үйлдвэрлэж байсан түүхэн уламжлал, монголд хэрэглэгдэж байсан цаасны талаар хийсэн хамтарсан судалгааны тайланг бэлэн болгож, хэвлэлтэнд шилжүүлээд байна.

*- Гадаад арга хэмжээ*

- 2009 оны 2 сараас эхлэн АНУ-ын Хьюстон, Дэнвер хотуудад гарч байгаа “Чингис хааны Монгол, Эзэнт гүрний амьдрал” үзэсгэлэнгийн үзмэр, эд өлгийн зүйлсийг хүргэж өгч, үзэсгэлэнг дэглэхэд тус төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа нь 2009 оны 2-р сарын 10-наас 20-ны хооронд 10 хоног Хьюстон хотын музейд, 2009 оны 10 дугаар сард үзэсгэлэнг Дэнвер хотод шилжүүлэн гаргахад тус тус очиж ажилласан.
- Франц улсад зохион байгуулагдсан “Занабазарын бүтээлүүд” сэдэвт үзэсгэлэнгийн бэлтгэл ажилд оролцов.

*-Боловсруулсан ажлын талаар:*

- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (JICA)-аас олгодог соёлын буцалтгүй тусламжийн хөтөлбөрт хамрагдахаар соёлын өвийн оношилгоо судалгаа, сэргээн засварлах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах зорилгоор “Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо, судалгааны төхөөрөмж” нэртэй төслийг 2009 оны 8 дугаар сард өргөн барьсан бөгөөд уг төсөл нь Япон улсаас тус улсад суугаа Элчин сайдын яам болон Монгол Улсын Сангийн яамнаас дэмжлэг авч Япон улсын Засгийн газарт хүргэгдээд байна.
- АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэргэдэх Элчин сайдын нэрэмжит сангаас соёлын дурсгалыг хамгаалах тэтгэлэгт хөтөлбөрт “Шатаж гэмтсэн уран зургийг сэргээн засварлах” нэртэй төслийг 2009 оны 11 дүгээр сард өргөн барьсан бөгөөд уг төсөл эхний шатандаа амжилттай дэмжигдээд байна.

**Дүгнэлт:**

Соёлын өвийн төв нь 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд төлөвлөсний дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Улс, аймгийн музей, зарим нэг эрдэм шинжилгээний байгууллага, сүм хийдийг байгууллагынхаа бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардлагатай програм, техник хэрэгслээр хангаж, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэн, хууль эрх зүйн орчинг сайжруулж холбогдох журмыг шинэчлэн боловсронгуй болгоход арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Музейн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, үзмэрийн бүртгэлээ УНБМСанд ирүүлэхэд ахиц дэвшил гарч байгаа хэдий ч шаардлагын хэмжээнд хүрэхгүй, үзмэрээ бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сангаа бүрдүүлж, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд үзмэрийн бүртгэлээ хүргүүлэхэд улс, аймгийн музейнүүдийн өөрсдийн идэвхтэй үйл ажиллагаа хангалтгүй байна.

УНБМСанд ирүүлж байгаа үзмэрийн бүртгэл тодорхойлолтыг чанартай сайн хийж, бүртгэлийн програм, компьютер техник хэрэгслээ бүрэн эзэмших шаардлагатай байгааг музейн ажилтнууд анхаарах хэрэгтэй байна.

Үзмэрийн бүртгэн баримтжуулалт хийгдэхгүй эсвэл дутуу дулимаг хийгддэгийг далимдуулан музейн үзмэрийг хариуцагч сан хөмрөгч, музейн ажилтнууд нь үзмэрээ солих, хулгайлах, урлагийн бүтээлүүд галд шатаж устах зэрэг ноцтой явдлууд удаа дараа гарч байгаад сургамж авч улс, аймгийн музейнүүд үзмэрээ бүртгэн баримтжуулж, мэдээллийн сан бүрдүүлэх ажлаа сайжруулахад анхаарах нь чухал байгааг онцлон тэмдэглэж байна.

Ялангуяа Гандантэгчилэн хийдэд хадгалагдаж байгаа соёлын өвийг бүртгэн баримтжуулахад, хосгүй үнэт дурсгалуудын гэрэл зургийг нь авч гэрчилгээг олгуулахад БСШУЯамны хүчтэй дэмжлэг туслалцаа хэрэгтэй байгаа юм.

Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтсийг тус төвийн бүтцэд нэмэгдсэнтэй холбоотойгоор тус хэлтсийн үйл ажиллагааны зардал байгууллагын төсөвд огт тусгадахгүй байна. Энэ зардалд Биет бус соёлын өвийн УНБМСан бүрдүүлэх болон хээр хөдөө судалгааны ажил, шавь сургалт зохион байгуулах зэрэг олон үйл ажиллагааны зардал тусгагдах ёстой ба бид 2010 онд 20 гаруй сая төгрөгийг нэмж тусгахаар санал оруулсан ч батлагдаж ирсэнгүй.

#### **Цаашид авах арга хэмжээний санал:**

“Улс, орон нутгийн музейн дүрэм”-ийн 3.5-д, “Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавих шаардлага” Монгол Улсын стандартын 9.3, 9.10-т тус тус бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээлийн санд бүртгэлээ бүртгүүлэх нь музейн үндсэн үйл ажиллагаа болохыг заажээ.

Иймд музейн үндсэн үйл ажиллагааны нэг болох үзмэрээ бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг сайжруулахад БСШУ-ны сайдын 2008 оны 154-р тушаалаар батлагдсан “Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх журам”-ын “Музейн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд, дүгнэх аргачлал”-д “Бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх” гэсэн заалт бүхий соёлын өвийн “RCH” бүртгэлийн програмын дагуу бүртгэсэн үзмэрийн тоо, байгууллагын бүртгэл-мэдээллийн сангийн бүрдүүлэлт, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгүүлсэн үзмэрийн бүртгэлийн тоо зэрэг шалгуур үзүүлэлтийг нэмж оруулах саналтай байна.

Сэргээн засварлах үйл ажиллагаанд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг улсын төсөв болон гадаадын хандивлагчдын дэмжлэгээр ойрын хугацаанд шийдвэрлэх,

Сэргээн засварлах ажилд байнга ашигладаг зарим нэр төрлийн хэрэгцээт материалууд нь дотоодын зах зээлд байдаггүй, гадаад зах зээлээс худалдан авахад өнөөгийн төсөв нь туйлын бага тул сэргээн засварлах ажлын материал худалдан авах төсвийг нэмэгдүүлэх,

Биет бус утга соёлын өвийн УНБМСанг бүрдүүлэх ажлын хүрээнд өмнөх төрийн бус байгууллагад хадгалагдаж байсан утга соёл болон аман өвийг дуу дүрс бичлэгээр баримтжуулсан видео хэрэглэгдхүүнийг улсын сан хөмрөгт хувиран авч хадгалахад



зориулан, хальс худалдаж авах болон хээр хөдөө судалгаа шинжилгээний ажилд зориулж жилд 20 орчим сая төгрөгийг шийдвэрлэж өгөх шаардлагатай байна.

БСШУЯ-ны дэд сайдаар ахлуулсан “Соёлын биет бус өв, түүний тээгчийг тогтоох үндэсний зөвлөл”-ийн ажлын хүрээнд соёлын биет бус өвийг уламжлан тээгчдийн улсын нэгдсэн бүртгэл жагсаалт гаргаж, ховор хосгүй төрлийг өвлөсөн билиг авъяастныг төрийн хамгаалалтад авах, сурсан эрдмээ хойч үед өвлүүлэх үүрэг, хариуцлагын тогтолцоонд хамруулах,

Яаралтай хамгаалах шаардлагатай биет бус соёлын өвийн төрөл зүйлийг хойч үед өвлүүлэх шавь сургалтыг тууль, цуур, товшуурын уламжлалт урлаг тэрчлэн лимбэ, бишгүүрийн битүү амьсгаа, монголын олон ястан угсаатны ардын бүжиг, бии биелгээ, морь, бөхийн цол, сур шагайн уухай, мал аж ахуйн холбогдолтой уриа дуудлага, ган сийлбэр, уран хайчилбар зэрэг урлахуйн уламжлалт хэлбэрүүд, мал аж ахуйн холбогдолтой тоног хэрэгслэл хийх, идээ ундаа бэлтгэх, мал маллагаа, үржил селекцийн уламжлалт технологи, хануур, хатгуурын аргаар малын өвчин эмгэгийг анагаах эрдэм ухааны уламжлал зэрэг ховор хосгүй төрлөөр орон нутагт зохион явуулах,

Соёлын биет бус өвийг таньж тогтоох, баримтжуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, судлах, оршин тогтнох чадварыг хангаж хамгаалах, олны хүртээл болгох, мартагдсан өвийн төрөл зүйлийг сэргээх олон талт асуудлыг иж бүрэн тусгасан үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,

Соёлын биет болон биет бус өвийн чиглэлээр мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, дадлагажуулж, мэргэшүүлэх сургалтанд хамруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

--- о 0 о ---

**2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний тайланд хавсаргасан хийгдсэн ажлуудын тайлангийн жагсаалт**

- Монголын Улсын Засгийн газраас баталсан “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн тайлан
- Улс, аймгийн музейгээс сүм хийдэд эзэмшүүлж байгаа үзмэрийн асуудлыг шийдвэрлэсэн тухай тайлан
- Улс, аймгийн музейгээс шилжүүлэх үзмэрээр Улаанбаатар хотод нэгдсэн үзэсгэлэн зохион байгуулсан тухай тайлан
- Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалуудад гэрчилгээ олгосон тухай ажлын тайлан
- 2009 онд сэргээн засварласан бүтээлүүдийн жагсаалт
- Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт орших Таван толгойн хүн чулууг цэвэрлэж бэхжүүлэн, хуулбар хийх ажлын хүрээнд хэв авсан ажлын тайлан
- Аялал жуулчлалын чиглэлд хамрагдсан зүүн бүсийн гурван дурсгалт газар танилцуулах самбар байрлуулсан тухай ажлын тайлан
- АНУ-ын Вилльямстоуны Сэргээн засварлах төвтэй хамтран зохион байгуулсан сургалт дадлага ажлын тайлан
- Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны дурсгал, Хэнтий аймгийн Баянхутаг сумын Сэрвэн хаалганы дурсгалыг хамгаалах бэхжүүлэх сэргээн засварлалтын ажлын тайлан
- Түүх, соёлын дурсгалыг гурван хөдөлгөөнт хэмжээс бүхий дижитал гэрэл зургаар баримтжуулахад Дошиша Их сургуулийн дижитал технологийн багтай хамтран ажилласан тухай ажлын тайлан
- АНУ-ын Хьюстон, Дэнвер хотуудад гарч байгаа “Чингис хааны Монгол, Эзэнт гүрний амьдрал” үзэсгэлэнгийн үзмэр, эд өлгийн зүйлсийг хүргэж өгч, дэглэхэд оролцсон тухай ажлын тайлан

**Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа 2009 онд гүйцэтгэсэн үл хөдлөх дурсгалын бүртгэл, тооллогын ажлын дэлгэрэнгүй тайлан**

- Дорнод, Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэн, тоолсон ажлын тайлан